



ТЕНДЕРТ ОРОЛЦОХ ХҮСЭЛТЭЙ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

АЗДТГ-ын байр А корпус 1 давхар,
8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 8849, 7038 8821, Факс: 7038 8848
Цахим шуудан: khuvsgul-tender@khs.gov.mn

2024.02.16 № 1/28
танай _____-ны № _____-т

Тодруулга авах хүсэлтэд хариу
хүргүүлэх тухай

Эрт илрүүлэг үзлэгт иргэдийг үе шаттайгаар хамруулах ажлын хүрээнд Эхо аппарат худалдан авах (Нэгдсэн эмнэлэг) ХӨАХААГ/20240202034 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг “Шинжьюки” ХХК-ийн 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 012/2024 дугаар албан бичгийг манай байгууллага цахим шуудангийн хаягаараа 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт: Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг захиалагчид тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно. Мөн Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/261 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн нэгдүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын зааварчилгааны 9 дэх хэсгийн “Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах” тухай заалтын 9.1-д Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно, 9.3-т Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана гэж тус тус заасан байна.

“Шинжьюки” ХХК нь тодруулга авах хүсэлтийг уг тендерийг нээх өдрөөс ажлын 3 хоногийн өмнө цахим шуудангаар ирүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт: “Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах хүсэлтийг захиалагчид тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно”, харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн нэгдүгээр бүлэгт заасан тендер шалгаруулалтын зааварчилгааны 9 дэх хэсгийн 9.3-т “Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана” гэж заасныг тус тус хангаагүй тул захиалагч тендерийн баримт бичгийн талаар тодруулга өгөхөөс татгалзаж байгааг мэдэгдье.



ДАРГА

Б.ДОЛЖИНСОРОГДОГ

6712002003